**МОНГОЛ УЛС**
**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 23 өдөр Дугаар А/572 Номгон

Хэмжил зүйн лабораторид тоног төхөөрөмж авахад хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Монгол Улсын Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6, Монгол Улсын Шадар сайдын Баянхонгор аймгийн Засаг даргатай 2024 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний 3.17, 3.18, 3.19, 3.25 дах заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Стандарт, хэмжил зүйн хэлтсийн чанар, стандартыг сайжруулах зорилгоор хэмжил зүйн лабораторид 2 төрлийн тоног төхөөрөмжийг худалдан авахад шаардлагатай 9,600,000 (Есөн сая зургаан зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д зөвшөөрсүгэй.

2.Тоног төхөөрөмж худалдан авах ажлыг чанартай зохион байгуулж, тайлагнахыг Стандарт, хэмжил зүйн хэлтэс (Н.Шагдарсүрэн)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА Д.МӨНХСАЙХАН

624211457